



УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН
ТӨВ ЭМНЭЛЭГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

ШУДАРГА, ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170

Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,

Цахим шуудан: contact@afccp.gov.mn,

Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024.03.22 № 01/413

танай _____-ны № _____-т


Тендер түдгэлзүүлэх тухай

Танай эмнэлгээс 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдөр зарласан “Эм эмнэлгийн хэрэгсэл, оношлуур худалдах авах” УБТЗТЭ/20240102001 дугаартай тендерийн баримт бичгийн “Багц-11”-т холбогдох гомдлыг “Агниста фарм” ХХК-аас ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянаж байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсэгт заасны дагуу гомдлыг хянан хэлэлцэж шийдвэрлэх хүртэлх хугацаанд уг тендерийн “Багц-11”-т холбогдуулан гаргасан захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилт, тендер шалгаруулалтын баримт бичгийг авах, нээлт хийх үйл ажиллагааг түр түдгэлзүүлж байгааг үүгээр мэдэгдэж байна.

Уг тендер шалгаруулалттай холбогдох тайлбар болон үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, тендерийн баримт бичиг бусад баримт материалыг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРГА



Б.БИЛГҮҮН